

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төслийн 2025 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/57/НА-СТА-ТХН

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2025 он

Санхүүгийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас:261663 Цахим хаяг: naramchimegts@audit.gov.mn
Аудитын менежер Б.Долгорсүрэн
Утас:261885 Цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn
Ахлах аудитор С.Отгонхорлоо
Утас: 261885 Цахим хаяг: otgonkhorloos@audit.gov.mn
Мишээл-Од Аудит ХХК-ийн захирал Т.Одончимэг
Утас:70169029 Цахим хаяг: info@misheelodaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

| | |
|--|----|
| 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ | 3 |
| 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ | 5 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 5 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 6 |
| 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 7 |
| 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 8 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 8 |
| 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА | 9 |
| 3.1 Төсөл хэрэгжих нэгж, түүний үйл ажиллагаа | 9 |
| 3.2 Төсөл хэрэгжих нэгжийн гадаад, дотоод орчин | 10 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 10 |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд | 10 |
| 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл | 11 |
| 4. АУДИТЫН ТАЙЛАН | 17 |
| 4.1 Ерөнхий зүйл | 17 |
| 4.2 Материаллаг байдал | 17 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт | 17 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 17 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 18 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 19 |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ | 20 |
| 5.2 Албан шаардлага | 20 |
| 5.3 Зөвлөмж | 21 |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ | 22 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АНУ | Америкийн нэгдсэн улс |
| БНСУ | Бугд найрамдах солонгос улс |
| БОН | Байгаль, орчны нөлөөлөл |
| БУА | Барилга угсралтын ажил |
| ДЦС | Дулааны цахилгаан станц |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| ТХН | Төсөл хэрэгжүүлэх нэгж |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| УБДС | Улаанбаатар дулааны сүлжээ |
| ТӨХК | Төрийн өмчит хувьцаат компани |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН НЭГДСЭН
ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖИЙН
ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ
Н.УУГАНЧИМЭГ ТАНАА

2026.03.27 № 06/822
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улс, Олон улсын хөгжлийн ассоциаттай байгуулсан гэрээний хоёр дахь үндсэн зорилго нь “Нийслэлийн гэр хорооллын дахин төлөвлөлт, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу бий болох орон сууцны хороолол, нийгэм ахуйн барилга байгууламжуудын хэрэглээг, эх үүсвэрүүдийн хүчин чадлын өргөтгөлтэй уялдуулан дулааны эрчим хүчээр хангах, шинэ гэр хорооллын хэсэг рүү өргөтгөх, нүүрстөрөгчийн давхар ислийн ялгаралтыг бууруулах” гэж заасан боловч хангалттай хэрэгжээгүй, төслийн нийт зарцуулалтын 8.2 хувь буюу 2 гэрээт ажил хийгдсэн байна.

Төслийн 1 дүгээр зорилтын хүрээнд 12.2 хос.км хуучин магистраль шугамыг өртгөтгөн шинэчилсэн, 2.5 хос.км дулааны магистраль шугамыг шинээр суурилуулсан, 1 насос станц шинэчлэх барилга угсралтын ажлуудыг тус тус гүйцэтгэсэн бөгөөд нийт хэрэгжилт 91.0 хувьтай байгаа нь дулааны шугамын нэвтрүүлэх чадварыг 1284 МВт/цаар нэмэгдүүлж, CO₂-ыг 1,294,253.3 тн-оор бууруулж, 4.93ГВт/ц эрчим хүч хэмнэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Сангийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 01/10803 дугаар албан бичигт 2025 онд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр болон хойшлуулах ажлын жагсаалтыг хүргүүлсэн байна. Уг жагсаалтад тусгаагүй 12,339,882.3 мянган төгрөгийн 2 ажил, хойшлуулсан 205,295.5 мянган төгрөгийн 2 ажил нийт 4 ажилд 12,545,177.8 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Бусад асуудал

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ҮЗЭГ
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Код | Дансны нэр, төрөл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|--------------|--|-------------------------|-----------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 5,909,978,198.30 | 167,864,192.11 |
| 31 | Мөнгөн хөрөнгө | 5,906,196,648.30 | 167,053,724.11 |
| 31211 | Төрийн сангийн харилцах /төгрөг/ | 223,752,494.72 | 146,980,468.57 |
| 31221 | Төрийн сангийн харилцах /валют/ | 5,682,444,153.58 | 20,073,255.54 |
| 33 | АВЛАГА | 106,000.00 | - |
| 33100 | Ажиллагчидтай холбоотой авлага | 106,000.00 | - |
| 3471 | Урьдчилгаа тооцоо | 3,675,550.00 | - |
| 34714 | Томилолтын урьдчилгаа | 3,675,550.00 | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | - | 810,468.00 |
| 35440 | Түлш,шатах тослох материал | - | 810,468.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 247,973,232.51 | 167,048,932.94 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 247,973,232.51 | 167,048,932.94 |
| 39200 | Биет хөрөнгө | 242,298,232.49 | 164,513,932.80 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 336,363,636.37 | 336,363,636.37 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (167,277,615.11) | (223,338,221.27) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 74,821,506.27 | 74,821,506.27 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (36,364,086.12) | (49,242,247.68) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 65,550,609.00 | 66,858,609.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (30,795,817.92) | (40,949,349.89) |
| 39300 | Биет бус хөрөнгө | 5,675,000.02 | 2,535,000.14 |
| 39301 | Програм хангамж | 11,350,000.00 | 11,350,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (5,674,999.98) | (8,814,999.86) |
| III | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 6,157,951,430.81 | 334,913,125.05 |
| IV | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 106,000.00 | 46,687,552.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 106,000.00 | 46,687,552.00 |
| 41300 | Өглөг | 106,000.00 | 46,687,552.00 |
| 41310 | Ажиллагчидтай холбогдсон өглөг | 106,000.00 | - |
| 41360 | Бусад өглөг | - | 46,687,552.00 |
| 41361 | Байгууллагад өгөх өглөг | - | 46,687,552.00 |
| V | ЦЭВЭР ХӨРӨНГӨ,ӨМЧИЙН ДҮН | 6,157,845,430.81 | 288,225,573.05 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 6,157,845,430.81 | 288,225,573.05 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 6,157,845,430.81 | 288,225,573.05 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 4,579,246,846.92 | 6,157,845,430.81 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 1,578,598,583.89 | (5,869,619,857.76) |
| VIII | НИЙТ ӨР ТӨЛБӨР ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 6,157,951,430.81 | 334,913,125.05 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

| Код | Дансны нэр, төрөл | Өмнөх он | Тайлант он |
|-------------|---|--------------------------|--------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 25,911,579,205.00 | 27,259,967,561.29 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 25,911,579,205.00 | 27,259,967,561.29 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 25,911,579,205.00 | 27,259,967,561.29 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 25,911,579,205.00 | 27,259,967,561.29 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 3,094,875,118.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 10,150,000.00 | 5,505,998.56 |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | 25,901,429,205.00 | 24,159,586,444.73 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 893,942,532.95 | 1,391,628,634.82 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 893,942,532.95 | 1,391,628,634.82 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 893,942,532.95 | 1,391,628,634.82 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 652,018,022.20 | 667,736,830.91 |
| 210101 | Үндсэн цалин | 652,018,022.20 | 667,736,830.91 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 81,502,253.00 | 83,459,117.61 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 75,480,733.00 | 56,752,199.97 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 1,505,380.00 | 6,676,729.41 |
| 210203 | ҮОМШ-ний даатгалын шимтгэл | 1,204,304.00 | 5,341,383.53 |
| 210204 | Ажилгүйдлийн шимтгэл | 301,076.00 | 1,335,345.88 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,010,760.00 | 13,353,458.82 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 67,913,093.00 | 67,800,376.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,916,078.00 | 1,238,866.00 |
| 210302 | Түлш, халаалт | 2,157,475.00 | 2,267,057.00 |
| 210304 | Байрны түрээс | 62,839,540.00 | 64,294,453.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 23,704,384.05 | 38,207,922.27 |
| 210401 | Бичиг хэрэг | 8,161,814.02 | 19,031,116.44 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,000,000.00 | 9,189,532.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,301,450.03 | 2,689,323.11 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 7,297,950.72 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 5,241,120.00 | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 7,440,199.83 | 30,124,277.27 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,480,000.00 | 3,825,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,960,199.83 | 26,299,277.27 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,353,464.00 | 364,915,062.19 |
| 210701 | Гадаад албан томилолт | - | 364,915,062.19 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,353,464.00 | - |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 49,613,983.03 | 48,433,899.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж-Зөвлөх үйлчилгээ | 17,581,800.00 | 7,920,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 33,900,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 181,170.00 | 160,996.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 373,000.00 | 1,112,376.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,800.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 11,090,415.53 | 2,694,401.40 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 203,797.50 | 324,125.60 |
| 210812 | Сургалтын зардал | 20,150,000.00 | 2,300,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,397,133.84 | 90,951,149.57 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | (32,413,766.00) | 8,718,850.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 40,810,899.84 | 82,232,299.57 |
| 213 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН | 25,017,636,672.05 | 25,868,338,926.47 |
| 2132 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | 56,833,286.09 | 100,782,859.28 |
| 145001 | Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз (бодит) | 56,833,286.09 | 100,782,859.28 |
| 5 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 23,495,871,374.25 | 31,838,741,643.51 |

| | | | |
|-----|---|----------------------------|----------------------------|
| 23 | Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл | 23,495,871,374.25 | 31,838,741,643.51 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V) | (23,439,038,088.16) | (31,737,958,784.23) |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН | 1,578,598,583.89 | (5,869,619,857.76) |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

| Код | Дансны нэр, төрөл | Өмнөх он | Тайлант он |
|---------|---|----------------------------|----------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 15,267,230,450.00 | 24,165,092,443.29 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 15,267,230,450.00 | 24,165,092,443.29 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 15,267,230,450.00 | 24,165,092,443.29 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 15,257,080,450.00 | 24,159,586,444.73 |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | 15,257,080,450.00 | 24,159,586,444.73 |
| 120009 | Бусад орлого | 10,150,000.00 | 5,505,998.56 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 8,940,875.00 | 6,070,000.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 8,940,875.00 | 6,070,000.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 8,940,875.00 | 6,070,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,940,875.00 | 6,070,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,940,875.00 | 6,070,000.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 15,258,289,575.00 | 24,159,022,443.29 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | - | 1,308,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 1,308,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 1,308,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 1,308,000.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | - | (1,308,000.00) |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | (13,642,796,791.30) | (29,896,857,367.48) |
| 14 | Бусад эх үүсвэр | 56,833,286.09 | 100,782,859.28 |
| 145001 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз | 56,833,286.09 | 100,782,859.28 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 13,699,630,077.39 | 29,997,640,226.76 |
| 232001 | Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл | 13,699,630,077.39 | 29,997,640,226.76 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 1,615,492,783.70 | (5,739,142,924.19) |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 4,290,703,864.60 | 5,906,196,648.30 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 5,906,196,648.30 | 167,053,724.11 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

| Код | Дансны нэр, төрөл | 1.1 Засгийн газрын оруулсан капитал | 1.2 Дахин үнэлгээний нөөц | 1.3 Хуримтлагдсан үр дүн | 1.4 Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|---------------------------------------|-------------------------------------|---------------------------|--------------------------|--|
| 1 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | - | - | 4,579,246,846.92 | 4,579,246,846.92 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | - | - | 4,579,246,846.92 | 4,579,246,846.92 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | - | - | 1,578,598,583.89 | 1,578,598,583.89 |
| 10 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | - | - | 6,157,845,430.81 | 6,157,845,430.81 |
| 11 | 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | - | - | 6,157,845,430.81 | 6,157,845,430.81 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | - | - | (5,869,619,857.76) | (5,869,619,857.76) |
| 20 | 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | - | - | 288,225,573.05 | 288,225,573.05 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

| Дансны код | Дансны нэр төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|------------|---|-------------------|-------------------|------------------|------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 33,200,000,000.00 | 33,123,510,896.76 | (76,489,103.24) | 99.8 |
| 21 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 33,200,000,000.00 | 33,123,510,896.76 | (76,489,103.24) | 99.8 |
| 232001 | Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл | 33,200,000,000.00 | 33,123,510,896.76 | (76,489,103.24) | 99.8 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 33,200,000,000.00 | 33,123,510,896.76 | (76,489,103.24) | 99.8 |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 33,200,000,000.00 | 33,123,510,896.76 | (76,489,103.24) | 99.8 |
| 350004 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | 33,200,000,000.00 | 33,123,510,896.76 | (76,489,103.24) | 99.8 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 5,906,196,648.30 | 5,906,196,648.30 | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 167,053,724.11 | 167,053,724.11 | - |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Төсөл хэрэгжих нэгж, түүний үйл ажиллагаа

Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банктай 2020 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр байгуулсан хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн гэрээний дагуу Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд хэрэгжинэ.

Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл нь төрөөс эрчим хүчний салбарт баримтлах дунд хугацааны хөтөлбөрийн биелэлтийг хангах, Нийслэлийн гэр хорооллын дахин төлөвлөлт, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу бий болох орон сууцны хороолол, нийгэм ахуйн барилга байгууламжуудын хэрэглээг эх үүсвэрүүдийн хүчин чадлын өргөтгөлтэй уялдуулан дулааны эрчим хүчээр хангах, техникийн боломжийг бүрдүүлэх, төвлөрсөн дулаан хангамжийн найдвартай ажиллагааг хангах үндсэн зорилгын хүрээнд, сонгосон төслийн талбайд дулааны сүлжээний хүчин чадлыг тэлж, үр ашигтай байдлыг сайжруулах зорилготой Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм. Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-тай 2021-2025 онд хамтран ажилласан байна.

Төслийн хөгжлийн зорилт:

- Дамжуулах хүчин чадлыг нэмэгдүүлэх (мегават) /Одоо байгаа дулаан дамжуулах шугам хоолойг өргөтгөх, шинэчлэх, Гэр хорооллын сонгогдсон бүсэд шинээр дулааны шугам суурилуулах, Улаанбаатар дулаан сүлжээ ТӨХК-ийн насос станцуудыг шинэчлэх/;
- Төслийн хүрээнд оруулсан хөрөнгө оруулалтад тулгуурлан эрчим хүчний ашиглалтын хугацааг хэмнэх (ГВт цаг);
- Төслийн хүрээнд оруулсан хөрөнгө оруулалтад тулгуурлан CO₂-ын ялгарлыг бууруулах.

Төсөл 2 бүрэлдэхүүн хэсэгтэй.

Бүрэлдэхүүн хэсэг 1: Хөрөнгө оруулалтын тэргүүлэх гурван дэд хэсгийг дэмжинэ. Үүнд:

- Бүрэлдэхүүн хэсэг 1.1: Одоо байгаа сонгогдсон Дулаан хангамжийн сүлжээг засварлах, шинэчлэх;
- Бүрэлдэхүүн хэсэг 1.2: Дулаан хангамжийн сүлжээг сонгогдсон шинэ гэр хорооллын хэсэг рүү өргөтгөх;
- Бүрэлдэхүүн хэсэг 1.3: Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн насос станцын шинэтгэл, сонгогдсон насос станцын тоног төхөөрөмжийг ухаалаг системд суурьшуулах хүчин чадлыг өргөтгөх ажлууд хийгдэнэ;

Бүрэлдэхүүн хэсэг 2: Чадавхыг бэхжүүлэх ба төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлнэ. Урт болон дунд хугацаанд бодлогын ба институцийн шинэчлэл хийх, Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн техник үйл ажиллагаа, итгэлцэл ба корпорацийн нөөцийн менежментийн чадавхыг бэхжүүлэх болон үр ашигтай төслийн хэрэгжилтийг хангахад чиглэнэ.

Бүрэлдэхүүн хэсэг 2.1:

- Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн үйл ажиллагаа болон итгэлцлийн чадавхыг бэхжүүлэх;
- Салбарын төлөвлөлт ба зохицуулалтыг сайжруулах;
- Институцын зохион байгуулалтад оролцогч нөлөө бүхий талуудад техникийн туслалцаа үзүүлэх;
- Бусад оролцогч талуудтай хамтран сургалт семинар зохион байгуулах;
- Сургалт семинараар дамжуулан УБДС ТӨХК-ийн ашигт ажиллагааны үнэлгээг дэмжих, санхүүгийн гүйцэтгэлийг сайжруулах зөвлөмж боловсруулах, чадавхыг бэхжүүлэх.

Бүрэлдэхүүн хэсэг 2.2:

- Төслийн удирдлагыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх. Үүнд:
- Байгаль орчин нийгмийн хүрээний бэлтгэл, хэрэгжүүлэх ажил;
- Мониторинг ба үнэлгээ;

- Төслийн менежментийн нэмэлт үйл ажиллагаа гэсэн 2 бүрэлдэхүүн хэсгээр хэрэгжиж байна.

3.2 Төсөл хэрэгжих нэгжийн гадаад, дотоод орчин

Төсөл хэрэгжүүлэх нэгж нь Эрчим хүчний тухай хууль, Барилгын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Замын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, УСНББОУС, Сангийн сайдын 2023 оны 229 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүрэлдэхүүн болох Засгийн газрын шугамаар авч ашиглаж буй хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр, Засгийн газрын тусгай санд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”-ыг үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг.

Тайлант хугацаанд төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төслийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,823,038.3 мянган төгрөгөөр буюу 94.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|--|--------------------|------------------|----------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 5,906,196.6 | 167,053.7 | (5,739,142.9) |
| Авлага | 106.0 | - | (106.0) |
| Урьдчилгаа | 3,675.6 | - | (3,675.6) |
| Бараа материал | - | 810.5 | 810.5 |
| Үндсэн хөрөнгө | 247,973.2 | 167,048.9 | (80,924.3) |
| Нийт хөрөнгө | 6,157,951.4 | 334,913.1 | (5,823,038.3) |
| Өр төлбөр | 106.0 | 46,687.6 | 46,581.5 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 6,157,845.4 | 288,225.6 | (5,869,619.8) |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 6,157,951.4 | 334,913.1 | (5,823,038.3) |

Дээрх хүснэгтээс харахад дансны үлдэгдэлд нөлөө бүхий дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 5,739,142.9 мянган төгрөгөөр буурсан нь 2024 оноос он дамжсан 5А дулааны магистрал шугамын үлдэгдэл 756,181.9 мянга, 9Г магистраль шугамын өргөтгөл, шинэчлэлтийн ажлын үлдэгдэл 713,237.9 мянга, 2А дулааны магистрал шугамын гуравдугаар үе шатны гүйцэтгэл 1,987,089.1 мянга, 1А шугамын эхний үе шатны гүйцэтгэлийн санхүүжилт 2,205,177.9 мянган төгрөгийг тус тус 2025 оны эхэнд санхүүжүүлсэнтэй холбоотой байна.
- Авлага дансны үлдэгдэл 106.0 мянган төгрөгөөр буурсан нь ажилтнуудад илүү олгосон татварын хөнгөлөлтийг цалингаас суутган авч, Татварын байгууллагад шилжүүлсэн байна.
- Урьдчилгаа дансны үлдэгдэл 3,675.6 мянган төгрөгөөр буурсан нь 2024 оны томилолтын тооцоог 2025 онд хаасан байна.
- Бараа материал дансны үлдэгдэл 810.5 мянган төгрөгөөр өссөн нь шатахууны картын үлдэгдэлтэй холбоотой байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 80,927.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны элэгдлийн зардал байна.
- Өр төлбөр дансны үлдэгдэл 46,581.5 мянган төгрөгөөр өссөн нь 29,687.5 мянган төгрөгийн бэлтгэн нийлүүлэгчийн төлбөрийг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр шилжүүлсэн боловч дансанд буцаж орж ирсэн, мөн 2025 оны аудитын төлбөр 17,000.0 мянган төгрөгийг бүртгэсэн.
- Засгийн газрын хувь оролцоо 5,869,619.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн бууралттай холбоотой байна.

Тус төслийн санхүүгийн тайланд санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой 11,350.0 мянган төгрөгийн 2 хэрэглээний програмууд бүртгэлтэй бөгөөд жилийн үйлчилгээний төлбөрт 1,505.0 мянган төгрөгийг төлдөг байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг гадаад зээлийн эх үүсвэрээс нийт 45,550,609.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн төслийн саналаас зардлыг 13,380,650.4 мянган төгрөгөөр бууруулж, 32,169,959.3 мянган төгрөгөөр баталсан.

Тайлант оны батлагдсан төсвийг 1,597,621.6 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон.

Төсөл хэрэгжүүлэгч нэгж 1 хөтөлбөр, 1 арга хэмжээг 30,572,337.1 мянган төгрөгийн гадаад зээлийн эх үүсвэрээс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр гадаад зээлийн эх үүсвэрээс 30,572,337.1 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна. Нийт зардлын гүйцэтгэл 30,005,018.2 мянган төгрөг буюу 98.1 хувьтай байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 30,005,018.2 мянган төгрөг буюу 98.1 хувьтай байгаа нь бараа, ажил үйлчилгээний зардлын төсвийг 276,632.4 мянган төгрөг, хөрөнгө оруулалтын зардлыг 290,686.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|-------|--|--------------|--------------|-----------|---------|
| 70207 | Гадаад зээл тусламжаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр | 30,572,337.1 | 30,005,018.2 | 567,318.9 | 98.1 |
| 80104 | Гадаад тусламжаар гүйцэтгэх ажил | 30,572,337.1 | 30,005,018.2 | 567,318.9 | 98.1 |

Судалгааны үр дүн: Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ. Тухайлбал:

- Тус байгууллагын ажилчид нь Сангийн сайдын 2021 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх” журмын дагуу хөдөлмөрийн гэрээнд тулгуурлан цалин хөлсийг тооцдог тул орон тооны цомхотголд хамаарахгүй.
- Хөдөлмөрийн гэрээнд унаа, хоолны хөнгөлөлт олгох заалт тусгаагүй тул тайлант онд зардал гараагүй.
- Тайлант онд БНСУ-д Төвлөрсөн дулаан хангамжийн салбар дахь цогц үйл ажиллагаатай танилцах, Финлянд, Эстони улсад техникийн сургалт, АНУ-д Сэргээгдэх эрчим хүчний нэгдсэн чуулга уулзалт гэх мэт 3 удаагийн гадаад томилолтын зардалд нийт 364,915.1 мянган төгрөгийг зарцуулсан.
- Байгаль орчин, нийгэм, менежментийн хүрээний сургалтын бичиг хэргийн зардалд 2,300.0 мянган төгрөг зарцуулсан байна.
- Хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулаагүй, төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл нь тайлант онд 2 хөтөлбөрийн 26 арга хэмжээнд 35,697,255.4 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 33,123,510.8 мянган төгрөг буюу 92.8 хувь байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

| № | Хөтөлбөр | Хэрэгжих хугацаа | Хүрэх үр дүн | Хэрэгжилтийн явц | Зарцуулах төсөв | Зарцуулсан төсөв |
|------------------------------|--|------------------|---|------------------|-----------------|------------------|
| Бүрэлдэхүүн хэсэг 1.1 | | | | | | |
| 1 | 5А магистраль ДШ,183-р цэгээс 237-р цэг дуустал 667.8 хос.м/Ф1000 БУА | 2022 - 2024 | Ашиглалтын хугацаа дууссан хуучин дулааны шугамыг өргөтгөн шинэчлэх ф800 голчийг ф1000 өргөтгөх | 100% | 648,824.2 | 648,824.2 |
| 2 | 5А магистраль, Зураг төсвийн тодотгол, зохиогчийн хяналт | 2022 - 2024 | Ажлын зураг төсвийн дагуу хийгдэж байгаа эсэхэд хяналт тавих | 100% | 107,357.7 | 107,357.7 |
| 3 | 9Г магистраль, ТК-32 дугаар цэгээс ДЦС-2-ын арын ТК-10 цэг хүртэлх шугамын өргөтгөл, шинэчлэлтийн ажил (одоо байгаа 2ф 400 мм-ийн голчтой суваггүй шугамыг 2Ф500 мм голчтой болгож өргөтгөх) | 2024 - 2025 | Ашиглалтын хугацаа дууссан хуучин дулааны шугамыг өргөтгөн шинэчлэх ф400 голчийг ф500 өргөтгөх | 100% | 713,237.9 | 713,237.9 |
| 4 | 9Г магистраль, ТК-32 дугаар | 2023 - | Ажлын зураг төсвийн | 100% | 26,290.9 | 26,290.9 |

Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | | |
|----|---|-------------|--|------|-------------|-------------|
| | цэгээс ДЦС-2-ын арын ТК-10 цэг хүртэлх шугамын өргөтгөл, шинэчлэлтийн (одоо байгаа 2ф400 мм-ийн голчтой суваггүй шугамыг 2Ф500 мм голчтой болгож өргөтгөх) ажлын зураг төсвийн тодотгол, зохиогчийн хяналтын зөвлөх үйлчилгээ | 2025 | дагуу хийгдэж байгаа эсэхэд хяналт тавих | | | |
| 5 | 2А магистраль, ДХ-165 цэгээс ДХ-221 цэг хүртэлх 2Ф350 мм-ийн голчтой 0.95 хос.км шугамыг 2Ф 500 мм болгон өргөтгөх ажил | 2023 - 2025 | Ашиглалтын хугацаа дууссан хуучин дулааны шугамыг өргөтгөн шинэчлэх ф350 голчийг ф500 өргөтгөх | 98% | 3,201,307.1 | 1,945,270.9 |
| 6 | 2А магистраль, ДХ-165 цэгээс ДХ-221 цэг хүртэлх 2Ф 50 мм-ийн голчтой 0.95 хос.км шугамыг 2Ф500 мм ажлын зохиогчийн хяналт | 2023 - 2025 | Ашиглалтын хугацаа дууссан хуучин дулааны шугамыг өргөтгөн шинэчлэх ф350 голчийг ф500 өргөтгөх | 100% | 73,181.8 | 41,818.2 |
| 7 | "2Д магистраль ДХ264 цэгээс ДХ269 цэг хүртэл 2ф250мм голчтой 0.282 хос.км шугамыг 2ф400 мм голчтой болгон өргөтгөн шинэчлэх барилга угсралтын ажил | 2024 - 2025 | Ашиглалтын хугацаа дууссан хуучин дулааны шугамыг өргөтгөн шинэчлэх ф250 голчийг ф400 өргөтгөх | 100% | 1,873,786.4 | 1,873,786.4 |
| 8 | "2Д магистраль ДХ264 цэгээс ДХ269 цэг хүртэл 2ф250мм голчтой 0.282 хос.км шугамыг 2ф 400 мм голчтой болгон өргөтгөн шинэчлэх барилга угсралтын ажил 1А магистраль ДХ-116-А6 цэгээс ДХ-116-А16 цэг хүртэл 2Ф400 мм-ийн голчтой 0.578 хос.км, ДХ116-А1 цэгээс ДХ116-А2 цэг хүртэл 2Ф 400 мм-ийн голчтой 0.150 хос.км нийт 0.730 хос.км шугамыг шинэчлэн сольж, төвшин өндөрлөх" барилга угсралтын ажил зөвлөх үйлчилгээ | 2024 - 2025 | Ажлын зураг төсвийн дагуу хийгдэж байгаа эсэхэд хяналт тавих | 100% | 87,203.6 | 87,203.6 |
| 9 | 1А магистраль ДХ-116-А6 цэгээс ДХ-116-А16 цэг хүртэл 2Ф400мм-ийн голчтой 0.578 хос.км, ДХ116-А1 цэгээс ДХ116-А2 цэг хүртэл 2Ф400мм-ийн голчтой 0.150 хос.км нийт 0.730 хос.км шугамыг шинэчлэн сольж, төвшин өндөрлөх" барилга угсралтын ажил | 2024 - 2025 | Ашиглалтын хугацаа дууссан хуучин дулааны шугамыг өргөтгөн шинэчлэх ф400 голчийг ф400 өргөтгөх төвшин өндөрлөх | 100% | 7,342,641.0 | 7,342,641.0 |
| 10 | 1А магистраль, ДХ-110 цэгээс ДХ-110-17 цэг хүртэл зайсан орчмын хэрэглэгчдийг дулаанаар хангадаг 2ф400мм-н 550 хос.м шугамыг 2ф600 мм болгох өргөтгөн шинэчлэх барилга угсралтын ажил | 2025 - 2026 | Ашиглалтын хугацаа дууссан хуучин дулааны шугамыг өргөтгөн шинэчлэх ф400 голчийг ф600 өргөтгөх | 100% | 4,713,450.0 | 4,675,251.0 |
| 11 | 1А магистраль, ДХ-110 цэгээс ДХ-110-17 цэг хүртэл зайсан | 2025 - 2026 | Ажлын зураг төсвийн дагуу хийгдэж | 100% | 39,515.4 | 39,515.4 |

Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | | |
|------------------------------|--|-------------|--|------|-------------|-------------|
| | орчмын хэрэглэгчдийг дулаанаар хангадаг 2ф400 мм-н 550 хос.м шугамыг 2ф600 мм болгох өргөтгөн шинэчлэх барилга угсралтын ажил ажил 1а-29 зөвлөх үйлчилгээ | | байгаа эсэхэд хяналт тавих | | | |
| 12 | ДЦС-2-ын баруун урд ҮХТ-43-аас Москва хороолол чиглэлд узель-18 хүртэлх угсрагдсан 2Ф800 мм-ийн голчтой дулааны гол шугамын дутуу ажлыг гүйцээх барилга угсралтын ажил | 2024 - 2025 | Сонгогдсон гэр хорооллын бүсийг төвлөрсөн дулаан хангамжид холбох, дахин төлөвлөлтийн орон сууцны хорооллын техникийн боломж бүрдүүлэх, агаарын бохирдлыг бууруулах | 100% | 431,142.4 | 431,142.4 |
| 13 | ДЦС-2 –ын баруун урд ҮХТ-43-аас Москва хороолол чиглэлд узель-18 хүртэлх угсрагдсан 2Ф800 мм-ийн голчтой дулааны гол шугамын дутуу ажлыг гүйцээх барилга угсралтын ажил Зөвлөх үйлчилгээ | 2024 - 2025 | Ажлын зураг төсвийн дагуу хийгдэж байгаа эсэхэд хяналт тавих | 100% | 11,946.3 | 11,946.3 |
| 14 | 1А магистралийн ДХ110-14 дугаар цэгээс Зайсан толгой орчмын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хангах 2Ф400 мм-ийн голчтой шугам татах зураг төсөв, барилга угсралтын ажил W-1А-32 | 2025 | Сонгогдсон гэр хорооллын бүсийг төвлөрсөн дулаан хангамжид холбох, дахин төлөвлөлтийн орон сууцны хорооллын техникийн боломж бүрдүүлэх, агаарын бохирдлыг бууруулах | 100% | 7,735,824.2 | 7,664,631.3 |
| 15 | УБДС ТӨХК-д цахилгаан редуктортой хаалт, ф800 мм голчтой хаалт | 2025 | УБДС ТӨХК-ийн | 100% | 786,000.0 | 763,673.2 |
| Бүрэлдэхүүн хэсэг 1.2 | | | | | | |
| 16 | Нарлаг худалдааны төвийн зүүн талаас бичил 6 дугаар хороолол буюу 28 дугаар сургуулийн баруун хойд тал хүртэл шинээр барих дулааны шугамын ажил | 2023 - 2025 | Сонгогдсон гэр хорооллын бүсийг төвлөрсөн дулаан хангамжид холбох, дахин төлөвлөлтийн орон сууцны хорооллын техникийн боломжийг бүрдүүлэх, агаарын бохирдлыг бууруулах | 88% | 4,388,841.1 | 3,677,460.4 |
| 17 | Нарлаг худалдааны төвийн зүүн талаас бичил 6 дугаар хороолол буюу 28 дугаар сургуулийн баруун хойд тал хүртэл шинээр барих дулааны шугамын ажил зөвлөх үйлчилгээ | 2023 - 2025 | Ажлын зураг төсвийн дагуу хийгдэж байгаа эсэхэд хяналт тавих | 89% | 74,361.0 | 51,953.2 |
| Бүрэлдэхүүн хэсэг 1.3 | | | | | | |

Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | | |
|---|---|-------------|--|------|---------------------|---------------------|
| 18 | Даралт өргөх насос станц №3-ын буцах талын 6кВ-ын тогтмол хурдны насосоор шинэчлэн солих ажил | 2024 - 2025 | 6кВ-ын тогтмол хурдны насосоор шинэчлэн солих ажил | 100% | 1,162,742.6 | 1,162,742.6 |
| 19 | Даралт өргөх насос станц №3-ын буцах талын 6кВ-ын тогтмол хурдны насосоор шинэчлэн солих ажлын хяналтын зөвлөх үйлчилгээ | 2024 - 2025 | Ажлын зураг төсвийн дагуу хийгдэж байгаа эсэхэд хяналт тавих | 100% | 12,898.8 | 12,898.8 |
| БХ 2.1 УБДС ТӨХК-ийн чадавх бэхжүүлэх | | | | | | |
| 20 | УБДС ТӨХК-ийн үйл ажиллагаа, хариуцлага, салбарын зохицуулалтыг сайжруулах бэхжүүлэх хүрээний сургалт чадавхжуулалт /гадаад+дотоод/ | 2024 - 2025 | УБДС ТӨХК-ийн ИТА чадавхжуулах | 100% | 457,619.0 | 364,796.4 |
| 21 | Засварын ажилчид болон гагнуурын ур чадварыг дээшлүүлэх, дадлагажуулах сургалтын өрөөний тохижилт, засварын ажил | 2023 - 2024 | Ажлын байрын нөхцөл байдлыг дээшлүүлж ажиллах таатай орчныг бүрдүүлнэ | 100% | 162,272.7 | 162,272.7 |
| 22 | Урьдчилсан дулаалгатай дулааны шугам, тоног төхөөрөмжийн стандартыг шинээр нэвтрүүлэх, дулааны шугамын угсралтын ажлын одоо мөрдөгдөж буй стандарт, норм дүрмийг шинэчлэх | 2024 - 2025 | Урьдчилсан дулаалгатай дулааны шугам, тоног, төхөөрөмжийн норм дүрэм шинэчлэх | 30% | 218,181.8 | - |
| 23 | Дулааны шугамын сүлжээний болон нэмэлт усны одоо мөрдөгдөж байгаа стандарт, нормыг шинэчлэн тогтоох | 2024 - 2025 | Дулааны шугамын сүлжээний болон нэмэлт усны одоо мөрдөгдөж байгаа стандарт, нормыг шинэчлэх | 30% | 81,818.2 | - |
| 24 | Тусгай тоноглол бүхий засварын авто машин | 2024 - 2025 | Засвар үйлчилгээнд ашиглагдаж байсан Forland маркийн 9042 УНЦ авто машины ашиглалтын хугацаа дууссан, шинээр засвар үйлчилгээний авто машины хэрэгцээ бий болсон | 100% | 355,800.7 | 355,800.7 |
| 25 | Байгаль орчин, нийгмийн менежментийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, зөвлөгөө өгөх, зөвлөмж боловсруулах зөвлөх үйлчилгээ | 2024 - 2025 | БУА-ын БОН-ийн зөвлөх үйлчилгээ үзүүлэн зөвлөмж боловсруулах | 100% | 43,181.8 | 43,022.7 |
| БХ 2.2 Төслийн хэрэгжилт болон менежмент | | | | | | |
| 26 | ТХН-ийн дотоод үйл ажиллагааны зардал | 2024 - 2025 | ТХН-ийн дотоод үйл ажиллагааг хэрэгжүүлэх | 100% | 947,828.9 | 919,972.7 |
| 2025 оны нийт дүн | | | | | 35,697,255.4 | 33,123,510.8 |

Тайлант онд зарим арга хэмжээний санхүүжилт хасагдсантай холбоотойгоор бүрэлдэхүүн 2.1-д тусгагдсан 300,000.0 мянган төгрөгийн 2 арга хэмжээг хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төслийн удирдах хорооны 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 01 дүгээр тогтоолын дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 6,152,870.6 мянган төгрөгөөр баталсан. Төлөвлөгөөнд 4,446,945.6 мянган төгрөгийн 1 ажил, 1,549,925.0 мянган төгрөгийн 5 бараа худалдан авах, 156,000.0 мянган төгрөгийн 1 зөвлөх үйлчилгээний ажил тусгагдсанаас гүйцэтгэлээр 5,122,125.2 мянган төгрөгийн 3 гэрээ байгуулж, 83.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсөл хэрэгжүүлэх нэгж, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Мишээл-Од Аудит ХХК-ийн ахлах аудитор М.Цэнд-Аюуш, аудитор П.Энхцэлмэг нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг чанарын хяналтын менежер Э.Энхцэцэг, захирал Т.Одончимэг, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор С.Отгонхорлоо, аудитын менежер Б.Долгосүрэн, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 01/01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нийт зардлын 24,389,813.9 мянган төгрөгийн 1.0 хувь буюу 243,898.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага тэвчиж болох зардлуудыг гаргахгүй байх, зайлшгүй шаардлагатай зардлуудыг эрэмбэлэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 16,893,239.8 мянган төгрөгийн зөрчлөөс 4,348,062.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 12,545,177.8 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс 166 мэдээллийг хуулийн хугацаанд иж бүрэн оруулсан бөгөөд 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн,

хугацаа болоогүй 1 мэдээлэл байна. Мөн Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 4 удаагийн 4,348,062.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг хугацаа хоцорч мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь байршуулдаггүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Сангийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 01/10803 дугаар албан бичгээр 2025 онд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр болон хойшлуулах ажлыг жагсаалт хүргүүлсэн байна. Уг жагсаалтад тусгаагүй 12,339,882.3 мянган төгрөгийн 2 ажил, хойшлуулсан 205,295.5 мянган төгрөгийн 2 ажил нийт 4 ажилд 12,545,177.8 мянган төгрөгийн санхүүжилт гаргасны нэг ажлын барилга ашиглалтад ороогүй, хэрэглэгчид холбогдоогүй байна.

Энэ нь Монгол Улсын Их Хурлын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн "Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хууль баталсан холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" 54 дүгээр тогтоолын 3-т "гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих төслүүдийн үр ашгийн эрэмбийг гаргаж, удаашралтай байгаа төслүүдийг цаашид хэрхэн шийдвэрлэх талаар санал боловсруулан 2025 оны хоёрдугаар улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах", 4-т "шинээр авах гадаад зээлийн санхүүжилтийг эдийн засгийн өсөлтийг дэмжих, бүсчилсэн хөгжлийн бодлого, томоохон дэд бүтцийн хөрөнгө оруулалтад чиглүүлж, цаашид хувийн хэвшил хийх боломжтой төслүүдийг гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гадаад зээлийн хөрөнгөөр төслийн зорилтот түвшинд нийцээгүй, ажил гүйлгээг санхүүжүүлэхгүй байх, дээд шатны төсвийн захирагчаас өгсөн үүрэг, чиглэлийг мөрдөж ажиллах зөвлөмж өглөө.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, худалдан авах ажиллагаа нь Монгол Улсын Их Хурлын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн "Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хууль баталсан холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" 54 дүгээр тогтоолын холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитын гэрээг Сангийн яамны зөвшөөрөл хүлээж хойшлуулан 2026 оны 1 дүгээр сард байгуулсан тул завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 8,728,196.3 мянган төгрөгийн 1 зөрчлийг арилгах албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 37,595,473.3 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгснөөс тайлант онд 1 албан шаардлага, 3 зөвлөмжийг хэрэгжүүлж бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|-----------------|------------------------|---------------------|----------|---------------------|--------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 1 | 8,728,196.3 | 1 | 8,728,196.3 | 100.0 |
| Зөвлөмж | 3 | 37,595,473.3 | 3 | 37,595,473.3 | 100.0 |
| Нийт дүн | 4 | 46,323,669.6 | 4 | 46,323,669.6 | 100.0 |

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төслийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн анхаарал татсан асуудал байхгүй байна.

Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг сайжруулахтай холбоотой дараах саналуудыг хүргүүлж байна. Үүнд:

1. Журмын хоёрдугаар хавсралтаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт болон Сангийн яамны finperform.mof.gov.mn сайт дахь маягт хоорондын зөрүүг арилгах.
2. Журмын гуравдугаар хавсралтаар батлагдсан дансны жишиг жагсаалтыг дээрх Сангийн яамны шинэ сайттай уялдуулах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 19,836.6 мянган төгрөгийн 5 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

- Мөнгөн гүйлгээний тайлангийн цэвэр мөнгөн гүйлгээний дүн тооцооллын хувьд алдаатай буюу 108.0 мянган төгрөгөөр зөрүүтэй;
- Гадаадын эх үүсвэрээс санхүүжих дансны мөнгөн орлогын дүнг “Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих” дансанд орлогын дансны ангиллыг буруу бүртгэсэн;
- Мөнгөн гүйлгээний тайлан болон мөнгөн хөрөнгийн журналын цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, НДШ-ийн зардлын дүнгүүд 13,766.6 мянган төгрөгөөр зөрүүтэй;
- Санхүүгийн үр дүнгийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардлуудыг тулгахад 210901 кодтой Бараа үйлчилгээний бусад зардлын данс 5,962.0 мянган төгрөгөөр зөрүүтэй;
- Мөнгөн гүйлгээний тайлангийн Нийгмийн даатгалын шимтгэлийг эдийн засгийн ангиллаар салган бүртгээгүй, 210201-Тэтгэврийн даатгал ангиллаар бүх гүйлгээг хийсэн;

Аудитаар нийт 10,740.9 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд 5,355.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 5,385.9 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 10,740.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 233,157.2 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1. Тайлант онд “2А магистраль, ДХ-165 цэгээс ДХ-221 цэг хүртэлх 2Ф350 мм-ийн голчтой 0.95 хос.км шугамыг 2Ф500 мм болгон өргөтгөх” 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан, 11,738,125.8 мянган төгрөгийн дүнтэй гэрээний хугацааг 2 удаа сунгаж 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр болгон өөрчилсөн боловч ажил дуусаагүй дахин 12 сараар сунган, гэрээнд өөрчлөлт хийгээгүй, гэрээний 4 дүгээр заалтыг мөрдөж ажиллаагүй, гэрээний тусгай нөхцөлд тусгасан “гүйцэтгээгүй ажлын дүнд 0.05 хувиар алданги тооцно” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2-т “Худалдан авах гэрээ болон ерөнхий гэрээний үүргийн гүйцэтгэлийн явцад дараах зүйлийг хориглоно”, 40.2.1-т “энэ хуулийн 40.1-д зааснаас бусад үндэслэлээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний заалтыг мөрдөж ажиллаагүй, гэрээний тусгай нөхцөлд тусгасан гүйцэтгээгүй ажлын дүнд алданийг 0.05 хувиар тооцно гэж заасныг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2. Тайлант онд Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн засварын ажилчид болон гагнуурчдын ур чадварыг дээшлүүлэх, дадлагажуулах сургалтын өрөөний тохижилт, засварын ажлын 178,500.0 мянган төгрөгийн гэрээг байгуулахдаа 5,355.0 мянган төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг байршуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т “Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана” гэж заасныг зөрчсөн байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: 1. Гүйцэтгэлийн баталгаа гаргуулан аваагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шатахууны зарцуулалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус төслийн дансанд бүртгэлтэй 02-27 УБҮ улсын дугаартай тээврийн хэрэгслийг Эрчим хүчний яам ашиглаж, тайлант онд 5,385.9 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан журмын 1 дүгээр хавсралт “Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтантай байгуулах хөлсөөр ажиллах гэрээний загвар”-ын 6 дугаар зүйлийн 6.1-д “Ажилтан нь Захиалагчаас хариуцуулж өгсөн бүтээгдэхүүн, машин техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, мөнгөн болоод биет эд зүйлс /үнэт цаас/, тооцоо, мэдээ, санхүүгийн баримтын бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүй эзэмших, эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүй бусад шилжүүлэхгүй байх үүрэгтэй” гэж заасныг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| № | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|--|------------|-----------------|-----------------------------------|------------|--------------------------|-----------------|------------|-----------------|--------------|------------|----------|------------|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулаагүй | | Тоо | Дүн |
| | | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| 1 | Мөнгөн гүйлгээний тайлангийн цэвэр мөнгөн гүйлгээний дүн тооцооллын хувьд алдаатай буюу 108.0 мянган төгрөгөөр зөрүүтэй | 1 | 108.0 | | | 1 | 108.0 | 1 | 108.0 | | | | |
| 2 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих дансны мөнгөн орлогын дүнг “Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих” дансанд орлогын дансны ангиллыг буруу бүртгэсэн | 1 | | | | 1 | | 1 | | | | | |
| 3 | Мөнгөн гүйлгээний тайлан болон мөнгөн хөрөнгийн журналын цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, НДШ-ийн зардлын дүнгүүд 13,766.6 мянган төгрөгөөр зөрүүтэй | 1 | 13,766.6 | | | 1 | 13,766.6 | 1 | 13,766.6 | | | | |
| 4 | Санхүүгийн үр дүнгийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардлуудыг тулгахад 210901 кодтой Бараа үйлчилгээний бусад зардлын данс 5,962.0 мянган төгрөгөөр зөрүүтэй | 1 | 5,962.0 | | | 1 | 5,962.0 | 1 | 5,962.0 | | | | |
| 5 | Мөнгөн гүйлгээний тайлангийн Нийгмийн даатгалын шимтгэлийг эдийн засгийн ангиллаар салган бүртгээгүй, 210201-Тэтгэврийн даатгал ангиллаар бүх гүйлгээг хийсэн | 1 | | | | 1 | | 1 | | | | | |
| | Дүн | 5 | 19,836.6 | 0 | 0.0 | 5 | 19,836.6 | 5 | 19,836.6 | 0 | 0.0 | 0 | 0.0 |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|--|-------------|-----------------|---------------|------------|-----------------|----------------|----------|----------------|-----------------------------------|------------|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцох албан шаардлага | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Тус төслийн дансанд бүртгэлтэй 02-27 УБУ улсын дугаартай тээврийн хэрэгслийг Эрчим хүчний яам ашиглаж, тайлант онд 5,385.9 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна. | 1 | 5,385.9 | | | | | 1 | 5,385.9 | | |
| 2 | Тайлант онд “2А магистраль, ДХ-165 цэгээс ДХ-221 цэг хүртэлх 2Ф350 мм-ийн голчтой 0.95 хос.км шугамыг 2Ф500 мм болгон өргөтгөх” 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан, 11,738,125.8 мянган төгрөгийн дүнтэй гэрээний хугацааг 2 удаа сунгаж 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр болгон өөрчилсөн боловч ажил дуусаагүй дахин 12 сараар сунган, гэрээнд өөрчлөлт хийгээгүй, гэрээний 4 дүгээр заалтыг мөрдөж ажиллаагүй, гэрээний тусгай нөхцөлд тусгасан “гүйцэтгээгүй ажлын дүнд 0.05 хувиар алданги тооцно” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна. | 1 | | | | 1 | | | | | |
| 3 | Тайлант онд Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн засварын ажилчид болон гагнуурчдын ур чадварыг дээшлүүлэх, дадлагажуулах сургалтын өрөөний тохижилт, засварын ажлын 178,500.0 мянган төгрөгийн гэрээг байгуулахдаа 5,355.0 мянган төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг байршуулаагүй байна. | 1 | 5,355.0 | | | 1 | 5,355.0 | | | | |
| | Дүн | 3 | 10,740.9 | 0 | 0.0 | 2 | 5,355.0 | 1 | 5,385.9 | 0 | 0.0 |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|-------------|---------------------|-----------------|--------------------|-----------------------------------|------------|----------|---------------------|
| | | | | Албан шаардлага | | Хариуцлага тооцох албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| 1 | Шилэн дансны цахим хуудсанд 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мөн Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 4 удаагийн 4,348,062.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг хугацаа хоцорч мэдээлсэн байна. | 1 | 4,348,062.0 | 1 | 4,348,062.0 | | | | |
| | Дүн | 1 | 4,348,062.0 | 1 | 4,348,062.0 | 0 | 0.0 | 0 | 0.0 |
| | Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| 1 | Сангийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 01/10803 тоот албан тоотоор 2025 онд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр болон хойшлуулах ажлыг жагсаалт хүргүүлсэн байна. Уг жагсаалтад тусгагдаагүй 12,339,882.3 мянган төгрөгийн 2 ажил, хойшлуулсан 205,295.5 мянган төгрөгийн 2 ажил нийт 4 ажилд 12,545,177.8 мянган төгрөгийн санхүүжилт гаргасны нэг ажлын барилга ашиглалтад ороогүй, хэрэглэгчид холбогдоогүй байна. | 1 | 12,545,177.8 | | | | | 1 | 12,545,177.8 |
| | Дүн | 1 | 12,545,177.8 | 0 | 0.0 | 0 | 0.0 | 1 | 12,545,177.8 |
| | Нийт дүн | 2 | 16,893,239.8 | 1 | 4,348,062.0 | 0 | 0.0 | 1 | 12,545,177.8 |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 823/A0150092

Улаанбаатар хот

САГ - 2026/57/НА - СТА - ТХН

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 4 мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 4 удаагийн 4,348,062,000.00 /Дөрвөн тэрбум гурван зуун дөчин найман сая жаран хоёр мянган/ төгрөгийн зарлагын гүйлгээг тус тус хугацаа хоцорч мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-д “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2.10-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь байршуулдаггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний салбарын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн Төслийн зохицуулагч /Н.Ууганчимэг/, санхүүгийн ажилтан /Ц.Батбилэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
Т.ОДОНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-57.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 824/А0150092

Улаанбаатар хот

САГ-2026/57/НА - СТА - ТХН

Зөрчил таслан зогсоож тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн засварын ажилчид болон гагнуурчдын ур чадварыг дээшлүүлэх, дадлагажуулах сургалтын өрөөний тохижилт, засварын ажлын 178,500,000.00 /Нэг зуун далан найман сая таван зуун мянган/ төгрөгийн гэрээг байгуулахдаа 5,355,000.00 /Таван сая гурван зуун тавин таван мянган/ төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг байршуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хуульд заасны дагуу гүйцэтгэлийн баталгаа гаргуулан аваагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний салбарын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн Төслийн зохицуулагч /Н.Ууганчимэг/, санхүүгийн ажилтан /Ц.Батбилэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДӨЛГОРСҮРЭН
Т.ОДОНЧИМЭГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 825/АД150092

Улаанбаатар хот

САГ-2026/57/НА-СТА-ТХН

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд “2А магистраль, ДХ-165 цэгээс ДХ-221 цэг хүртэлх 2Ф350 мм-ийн голчтой 0.95 хос.км шугамыг 2Ф500 мм болгон өргөтгөх” 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан, 11,738,125,800.00 /Арван нэгэн тэрбум долоон зуун гучин найман сая нэг зуун хорин таван мянга найман зуун/ төгрөгийн дүнтэй гэрээний хугацааг 2 удаа сунгаж 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр болгон өөрчилсөн боловч ажил дуусаагүй дахин 12 сараар сунган, гэрээнд өөрчлөлт хийгээгүй, гэрээний 4 дүгээр заалтыг мөрдөж ажиллаагүй, гэрээний тусгай нөхцөлд тусгасан “гүйцэтгээгүй ажлын дүнд 0.05 хувиар алданги тооцно” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2-т “Худалдан авах гэрээ болон ерөнхий гэрээний үүргийн гүйцэтгэлийн явцад дараах зүйлийг хориглоно”, 40.2.1-т “энэ хуулийн 40.1-д зааснаас бусад үндэслэлээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.8-т “байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. “Гэрээний 4 дүгээр заалтыг мөрдөж ажиллаагүй, гэрээний тусгай нөхцөлд тусгасан гүйцэтгээгүй ажлын дүнд алдангийг 0.05 хувиар тооцно” гэж заасныг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний салбарын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн Төслийн зохицуулагч /Н.Ууганчимэг/, санхүүгийн ажилтан /Ц.Батбилэг/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
Т.ОДОНЧИМЭГ

